



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 6/44

Бор-өндөр сум

**Б.Уранчимэгийг туслах
сувилагчаар томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1 Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 тоот тогтоолын 2 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 тоот тогтоолын 6 дугаар хавсралт, 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоолын хавсралт, 2020 оны “Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” А/69 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батсайханы Уранчимэгийг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Хэвтэн эмчлүүлэх тасгийн туслах сувилагчаар томилон ажиллуулсугай.
2. Б.Уранчимэгийг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн ТҮЭМ2 шатлалаар тогтоон үндсэн цалинг 1.283.000 (нэг сая хоёр зуун наян гурван мянга), Орон нутагт ажилласны нэмэгдэл цалингийн 40% 513.200 (таван зуун арван гурван мянга хоёр зуу), хоолны мөнгө өдрийн 10.000 (арван мянга) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-д зөвшөөрсүгэй.
3. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг Б.Уранчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАТБААТАР

